



**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

Х.БААСАНЖАРГАЛ

2026 оны 04 дүгээр сарын 20

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т “хуулиар ногдуулсан албан татвар төлөх;” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.21-д “Төрийн бодлого, татварын хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг хамгаалах, татах таатай орчныг бүрдүүлнэ” гэж заасан. Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4 дүгээр хавсралтад заасан Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн жагсаалтын 6-д “Аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, холбогдох бусад татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл”, 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна” гэж тус тус заасан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.2.4.6-д “Татвар ногдуулалтын актад гомдол гаргахад маргаантай татварын дүнгийн тодорхой хувийг урьдчилж төлүүлэх, эсхүл маргаантай татварын дүнг эскроу дансанд байршуулах шаардлагыг өөрчлөх, цуцлах” арга хэмжээг тусгасан.

Ийнхүү төрөөс татварын орчны тогтвортой байдал, хөрөнгө оруулалтыг дэмжих, хүний эрхийг хангах үүргийг хэрэгжүүлэх хүрээнд татварын хуулийн зохицуулалтыг

боловсронгуй болгох, татвар төлөгчид ээлтэй, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүссэн.

Дээрх хууль зүйн үндэслэлийн хүрээнд татварын таатай орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан иргэд, аж ахуйн нэгжүүд татварын хууль тогтоомжийг сайн дураараа мөрдөх явдлыг дэмжих, өртэй татварын төлөгчийг татварын өрөө төлөхийн тулд өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг хангах, татварын өрийг үл маргах журмаар барагдуулахдаа татвар төлөгчийн өдөр тутмын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, шүүхийн хяналтыг бий болгох замаар татвар төлөгчид ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулав.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Төрөөс бизнес эрхлэлтийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулах, хялбаршуулах, татвараас зугатах, зайлсхийх явдлын эсрэг тэмцэх, худалдааг хөнгөвчлөх үндсэн зорилгоор Татварын багц хуульд 2019 онд шинэчлэл хийсэн ч Татварын ерөнхий хууль болон Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 307 дугаар тушаалаар батлагдсан “Өртэй татвар төлөгчийн хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журам”-ын хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 21 мянган аж ахуйн нэгж, байгууллагын дансыг хааж, үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон гэж Монгол Улсын Татварын Ерөнхий газраас мэдээлсэн болно.

Иймд дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд үл маргах журмаар татвар төлөгчийн банкин дахь харилцах дансыг битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлсэн мэдээлэл, данс битүүмжилсэнтэй холбоотой татвар төлөгчөөс ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлтийн тоо, данс битүүмжилсний улмаас шүүхэд хандсан татвар төлөгчийн тоо зэрэг мэдээллийг Монгол Улсын Татварын Ерөнхий газраас 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/549 тоот албан бичгээр авсныг тоймловол дараах байдалтай байна. Үүнд:

- I. Данс битүүмжлэх ажиллагаа хэрэгжүүлсэн хуулийн этгээдийн судалгаа:
 - 2021 онд 2220 татвар төлөгч нийт 476.9 тэрбум төгрөгийн өр,
 - 2022 онд 7390 татвар төлөгч нийт 1.061.8 тэрбум төгрөгийн өр,
 - 2023 онд 5450 татвар төлөгч нийт 902.1 тэрбум төгрөгийн өр,
 - 2024 онд 6382 татвар төлөгч нийт 746.1 тэрбум төгрөгийн өр,
 - 2025 онд 9283 татвар төлөгч нийт 4.077.0 тэрбум төгрөгийн өртэй байна.

II. Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлийн 55.2.2-т заасны дагуу татварын өрийг үл маргах журмыг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор татварын албанд ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ:

Өргөдөл ирүүлсэн		Шийдвэрлэсэн байдал		Тайлбар
Он	Татвар төлөгчийн тоо	Данс нээсэн	Данс нээгээгүй	
Нийт	4464	9547	424	

2021		5153		Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэр танилцуулах үед Коронавируст халдвар цар тахлын хугацаанд “Үйлчилгээнд суурилсан татвар хураалт” чиглэлийг баримтлан нээсэн.
2022	348	348		Татвар төлөх хуваарь ирүүлсэн
2023	538	538		Татвар төлөх хуваарь ирүүлсэн
2024	1947	1947	190	НӨАТ-ын падааны зөрчилтэй болон татварын өрөө бүрэн төлөөгүй, татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдлүүлэх нөхцөл шаардлага хангаагүй.
2025	1565	1561	234	НӨАТ-ын падааны зөрчилтэй болон татварын өрөө бүрэн төлөөгүй, татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдлүүлэх нөхцөл шаардлага хангаагүй.

Үүнээс харахад 2024 оноос өмнө татвар төлөгчдөд татвараа төлөх хугацаа буюу татвар төлөх хуваарь ирүүлсэн тохиолдолд дансыг нь нээж байсан бол 2024, 2025 онуудад татвар төлөх хуваарь гаргах буюу урьдчилсан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхгүйгээр дансыг нь хааж байна.

Харин Татвар төлөгчийн арилжааны банкин дахь данс битүүмжилснээс шүүхэд хандсан аж ахуй нэгжийн мэдээг үзэхэд 2020 онд 1, 2024 онд 2 татвар төлөгч хандсан бөгөөд эдгээрийг анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн байна.

Олон улсын валютын сангаас 2022 онд хийсэн “Монгол Улс: Татварын албаны үйл ажиллагааг үнэлэх хэрэгслийн тайлан”-д дурдсанаар Монгол Улсын татварын албаны үйл ажиллагааг нийт 32 үзүүлэлтээр үнэлэхэд үйл ажиллагааны эрсдэл, татварын тайлангийн хамрагдалт, татварын үнэн зөв тайлагнал, татварыг хугацаанд нь төлж буй байдал зэрэгтэй холбоотой үзүүлэлтүүд хангалтгүй үнэлгээ авсан байна.

Түүнчлэн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох зорилгоор 2022 онд жижиг, бичил сегментийн аж ахуйн нэгж болон иргэдээс нийт 78 үзүүлэлтээр үндэслэн судалгаа авахад татвар төлөгчдийн 18 хувь нь сургалт, зөвлөгөө, заавар, зөвлөмж өгдөггүй гэж, 25 хувь нь татвар төлөх хугацаа уян хатан биш гэж дүгнэсэн байна. Данс битүүмжлэх арга хэмжээ нь татварын өр барагдуулахад дэмжлэг болохоос илүүтэйгээр татвар төлөгчийг дампуурах эрсдэлд оруулж байна. Улмаар данс битүүмжлэхэд шүүхийн урьдчилсан хяналт байхгүй, татвар төлөгчийн тайлбар өгөх боломж хязгаарлагдмал байгаа нь Үндсэн хуульд заасан өмчийн эрх, шударга шүүхээр хамгаалуулах эрхийн баталгаатай зөрчилдөхөд хүргэж байна.

Шинэ Зеланд, Австрали, Канад, Финланд зэрэг улс орнууд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мөн АНУ, Швед зэрэг улсад шүүхийн хяналтын

механизмыг нэвтрүүлжээ. Эдгээр улсуудад татвар төлөгчийг зөрчил гаргасны дараа шийтгэл хүлээлгэх бус, зөрчил гарахаас нь өмнө урьдчилан мэдээлж, тайлан гаргах, татвар төлөх үйл явцыг хялбар, ойлгомжтой болгох бодлого баримталдаг.

Эдгээр өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас үзэхэд татварын алба болон татвар төлөгчийн хооронд үүссэн харилцаа нь зөвхөн албадлага, шийтгэлд бус, харин харилцан итгэлцэл, нээлттэй байдал дээр тогтдог байна. Монгол Улсын хувьд ч татварын өр барагдуулах ажиллагаанд шүүхийн хяналтыг нэвтрүүлж, татвар төлөгчид үүссэн нөхцөл байдлаа тайлбарлах, өрөө хуваарийн дагуу төлөх бодит боломжийг олгох нь бизнесийн орчныг тогтворжуулахад чухал ач холбогдолтой. Үүнийг нэвтрүүлснээр татвар хураалтын үр нөлөөг бууруулахгүйгээр, харин ч татвар төлөгчдийн хуулиар ногдуулсан албан татвараа төлөх үүргийн хэрэгжилтийг дэмжиж, татвар төлөгч болон татварын алба хоорондын итгэлцлийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих суурь нөхцөл болох юм

Дээрх практик шаардлагын хүрээнд Монгол Улс татварын орчныг хялбаршуулж, сайжруулах, татвар төлөгч байгууллагуудад ээлтэй орчин нөхцөл бүрдүүлэх шаардлага үүсээд байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн төслийн гол зорилго нь татварын өр барагдуулах ажиллагааг хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн, татвар төлөгчийн бизнесийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино. Энэ хүрээнд татварын хяналтыг шүүхийн шийдвэрээр баталгаажуулах механизм болон урьдчилан сэргийлэх, уян хатан зохицуулалтыг дараах чиглэлээр нэвтрүүлнэ:

1.Урьдчилан зөвлөх үйлчилгээ: Татвар төлөгч зөрчил гаргахаас өмнө татварын албанаас урьдчилан сануулж, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.

2.Уян хатан хугацааг мөрдөх: Татвар төлөгчийн үйл ажиллагаа явуулсан хугацаа, татвар төлөлтийн түүх, хуулийн этгээдийн хэлбэр зэргийг харгалзан татварын өр төлөх хугацаанд ялгамжтай, уян хатан нөхцөлийг бий болгоно.

3.Бизнесийн тасралтгүй байдлыг хангах: Татвар төлөгчөөс татварын өр барагдуулах боломжит хуваарийг авч, түүнийг хэрэгжүүлэх замаар данс битүүмжлэх албадлагын арга хэмжээг хязгаарлаж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх боломжийг олгоно.

4.Шүүхийн хяналт: Данс хаах буюу зарлагын гүйлгээг зогсоох зайлшгүй нөхцөл байдлыг шүүхээр хянуулж, татвар төлөгчийн өмчлөх эрхийг хамгаалах шүүхийн хяналтын тогтолцоог бий болгоно.

5.Албадлагын арга хэмжээг хязгаарлах: Татварын алба нь зөвхөн шүүхээс тогтоосон хүрээ, хязгаарын дагуу битүүмжлэх мэдэгдэх хуудсыг үйлдэж, банкинд хүргүүлдэг байх процессыг тодорхой болгоно.

6.Нийгмийн баталгааг хангах: Данс битүүмжлэгдсэн хугацаанд ажилтнуудын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зарлагын гүйлгээг шүүхийн зөвшөөрлөөр сааталгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

7.Гомдол гаргах эрхийг хөнгөвчлөх: Татварын нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа маргаантай байгаа татварын дүнгийн тодорхой хувийг урьдчилж төлдөг зохицуулалтыг халж, иргэдийн шударга шүүхээр хамгаалуулах эрхийг баталгаажуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

Хуулийн төсөл батлагдсанаар татвар төлөгчдийн банкин дахь харилцах дансыг шууд хааж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг хязгаарладаг байдлыг өөрчлөх замаар татвар төлөгчдөд таатай орчин бүрдэнэ.

Энэ хүрээнд татварын алба татвар төлөгчийг алдаа гаргасны дараа хянан шалгаж акт, торгууль тавих бус, татварын тайланг залруулах хугацааг сунгаж, татвар төлөгчдөд чирэгдэл багатай, эрсдэлд суурилсан байдлаар хийж гүйцэтгэх нөхцөлийг бий болгох ач холбогдолтой.

Татвар төлөгчдийн дансыг шууд хааж үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл, боломжийг тасалдуулахгүйгээр төлбөр төлөх хуваарь гаргуулах замаар төлбөрийн асуудлыг шийдвэрлэх нөхцөл бий болгох зэрэг чухал үр нөлөөтэй. Товчхондоо энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын татварын тогтолцоог “шийтгэдэг” загвараас “дэмждэг, зөвлөдөг” олон улсын стандарт руу шилжүүлэх чухал алхам юм. Ялангуяа данс битүүмжлэх процессыг шүүхийн хяналтад оруулснаар бизнесийн эрх чөлөөг хамгаалах томоохон баталгаа болно гэж хууль санаачлагчийн хувьд үзэж байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулах бөгөөд Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг холбогдуулан боловсруулна.